

ЗАХИАЛАГЧ:  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖИЛ ТӨВИЙН  
ЗАХИРАЛ  
Ч.БАТ ЭРДЭНЭ

БАТЛАВ:

ГҮЙЦЭТГЭГЧ:  
АДМОН ПРИНТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  
Р.ЭНХБАТ

## ХЭВЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2016.09.05

№ A-XVI-16/69

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “Адмон принт” ХХК, /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ түүнийг төлөөлж захиалгын менежер Уламбаярын Баттуяа нөгөө талаас Эрүүл Мэндийн Хөгжил Төв /цаашид “Захиалагч” гэх/, түүнийг төлөөлөн Эрүүл Мэндийн Хөгжил Төвийн Судалгаа, төлөвлөлт, статистик мэдээллийн албаны дарга Ч.Зулцэцэг нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ нар харилцан тохиролцож дараах нөхцөлөөр байгуулав.

### 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Гүйцэтгэгч нь энэ гэрээний хавсралт №1-д заасан бүтээгдэхүүнийг загвар, тоо хэмжээ, үнэ, чанарын шаардлагын дагуу хийж гүйцэтгэх, захиалагч захиалсан бүтээгдэхүүнийг хүлээн авч, төлбөр тооцоог цаг тухайд нь хийж гүйцэтгэхтэй холбоотой харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.
- 1.2. Энэхүү гэрээний хавсралт, нэмэлт, өөрчлөлт, захиалгын хуудас, бүтээгдэхүүн хүлээлцсэн акт болон төлбөр төлсөн баримт зэрэг нь гэрээний салшгүй хэсэг байна.

### 2. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Бүтээгдэхүүнийг ажлын 3-5 хоногт хэвлэж бэлэн болгоно.
- 2.2. Гүйцэтгэгч тогтоосон хугацаанд бүтээгдэхүүнийг нийлүүлэх үүрэгтэй.
- 2.3. Гүйцэтгэгч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас бүтээгдэхүүнийг гэрээгээр тохиролцсон хугацаанд хэсэгчлэн болон бүхэлд нь нийлүүлэх боломжгүй бол энэ тухай захиалагчид нэн даруй мэдэгдэнэ.
- 2.4. Гэрээний 2.3-т заасан нөхцөл үүссэн бол талууд хугацааг дахин харилцан тохиролцож болно. Энэ тохиолдолд нэмэлт гэрээ хийж хавсралтаар оруулна.

### **3. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1. Эх бэлтгэлийн ажлыг Гүйцэтгэгч тал хийх болсон тохиолдолд эх бэлтгэлийн ажлын явцад хяналт тавьж, зөвлөх үүрэгтэй хүнийг томилон ажиллуулна.
- 3.2. Захиалагч захиалгат ажлын хэв загвар, өнгө дүрс, тоо ширхэг болон өөрийн бусад хэрэгцээтэй бүх мэдээллийг гүйцэтгэгчид өгнө.
- 3.3. Эх бэлтгэлийн ажил дууссан үед Гүйцэтгэгч хэвлэлийн эхийн дардсыг Захиалагчид гаргаж өгөх бөгөөд Захиалагч сайтар хянаж шалгасны үндсэн дээр хэвлэлтэд шилжүүлэхийг зөвшөөрч баталгаажуулна.
- 3.4. Захиалагч нь бэлэн болсон захиалгат ажлыг нэг бүрчлэн тоолж хүлээн авах бөгөөд биет байдлын доголдолтой болон үйлдвэрлэлийн алдаатай бүтээгдэхүүн байгаа эсэхийг захиалгат ажлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор Гүйцэтгэгчид мэдэгдэж солиулж авах, эсвэл төлбөрийн хөнгөлөлттэй үнээр тооцон авах эрхтэй.
- 3.5. Гэрээний 3.4-д заасан хугацааг захиалагч хэтрүүлсэн тохиолдолд үйлдвэрлэлийн алдаатай болон биет байдлын доголдолтой бүтээгдэхүүнийг сольж авах, үнийг бууруулахыг шаардах эрхгүй.
- 3.6. Захиалагч гэрээгээр тохиролцсон бүтээгдэхүүний үнийг төлөх үүрэгтэй бөгөөд, захиалсан боловч хүлээн аваагүй байгаа бүтээгдэхүүний төлбөрийг мөн бүрэн төлөх үүрэгтэй.

### **3. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 4.1 Захиалгат ажлын эх загварыг Захиалагчийн хэрэгцээ шаардлагын дагуу гаргаж, Захиалагчаар баталгаажуулсны дараа хэвлэлтэнд шилжүүлэн чанарын өндөр түвшинд хэвлэж, тогтоосон хугацаанд Захиалагчид хүлээлгэн өгнө.
- 4.2 Захиалгат ажлыг гүйцэтгэхээс өмнө эх загварыг Захиалагчийн шаардлагын дагуу тохиролцсон хугацаанд бэлтгэх бөгөөд Захиалагч зөвшөөрч гарын үсэг зурж баталгаажуулсан загвараар бүтээгдэхүүнийг хэвлэнэ.
- 4.3 Гүйцэтгэгч хэвлэлийн чанарын шаардлага хангасан, биет байдлын болон үйлдвэрлэлийн доголдолгүй бүтээгдэхүүнийг Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 4.4 Захиалагч ажлын 5 /тав/ хоногийн дотор аливаа гомдол гаргаагүй тохиолдолд захиалгат ажлыг бүрэн хүлээлгэн өгсөнд тооцно.
- 4.5 Захиалагч бүтээгдэхүүнийг хүлээн авснаас хойш бараа бүтээгдэхүүнд үүссэн доголдлыг гүйцэтгэгч хариуцахгүй.
- 4.6 Гүйцэтгэгч нь Захиалагчийн захиалсан бүтээгдэхүүний тоо ширхэгийн дагуу хэвлэмэл бүтээгдэхүүнийг нийлүүлэхийг хичээнгүйлэн ажиллах боловч захиалсан тооноос 2% илүү болон дутуу гарсан тохиолдолд хэвлэлийн үйлдвэрлэлийн хэвийн үзэгдэл гэж үзэн төлбөр тооцоог хүлээлгэн өгсөн тоо ширхэгийн дагуу нэхэмжилнэ.
- 4.7 Хүлээлгэн өгсөн бүтээгдэхүүний тоо 2%-иас илүү тоогоор дутсан тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу дутуу гарсан бүтээгдэхүүнийг нөхөн хэвлэж гүйцээх үүрэгтэй.



- 4.8 2 хувиас дээш илүү гарсан бүтээгдэхүүнийг Захиалагч хүлээн авахаас татгалзсан тохиолдолд илүүдэл бүтээгдэхүүнийг Захиалагчийн төлөөлөгчийг байлцуулан устгалд оруулна.
- 4.9 Гүйцэтгэгч гэрээний дагуу бүтээгдэхүүнийг хэвлэж дууссан тохиолдолд Захиалагчаас төлбөр тооцоо хийж дуусгахыг шаардах эрхтэй.

#### 4. ТООЦОО ХИЙХ ЖУРАМ

- 5.1. Гүйцэтгэгч нь захиалагчид бүтээгдэхүүний нэг бүрийн болон нийт үнийн саналыг танилцуулж, гүйцэтгэгч тохирсон хэмжээгээр үнийг төлнө. Урьдчилгаа 60 хувь 2 284 500 төгрөг төлж, үлдэгдэл 40 хувь буюу 1 523 000 төгрөгийг бэлэн бүтээгдэхүүн хүлээн авахаас өмнө төлж барагдуулна.
- 5.2. Захиалагч нь бүтээгдэхүүнийг хүлээн авахдаа шалган тоолж авах бөгөөд Гүйцэтгэгчээс бүтээгдэхүүний үнэ, тоо ширхэгийг тэмдэглэсэн гарын үсэг бүхий зарлагын баримтаар хүлээлгэн өгч, гарын үсэг зуруулснаар барааг хүлээн авсанд тооцно.
- 5.3. Захиалагч нийт захиалсан бүтээгдэхүүний нийт төлбөрийн график хавсралт №1 тусгасан болно.
- 5.4. Захиалагч нь бүтээгдэхүүний төлбөрийг бэлнээр болон дансаар төлөх боломжтой бөгөөд дансаар төлөх тохиолдолд Гүйцэтгэгчийн Худалдаа Хөгжлийн Банкны 499005828 тоот төгрөгийн данс эсвэл ХААН банкны 5014257025 тоот төгрөгийн дансанд тус тус шилжүүлнэ.
- 5.5. Энэхүү гэрээний 5.3 дахь заалт болон хавсралтад заасан хугацаанд төлбөр тооцоог хийж барагдуулаагүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутам Захиалагч Иргэний хуулийн 232-р зүйлийн 232.6-д заасны дагуу гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5%-тай тэнцэх хэмжээгээр алданги тооцож гүйцэтгэгчид төлнө.
- 5.6. Захиалагч бүтээгдэхүүний төлбөрөө шилжүүлсэн баримтыг үндэслэн төлбөрийг төлсөнд тооцно.

#### 6. ХАРИУЦЛАГА

- 6.1 Бүтээгдэхүүний эх загварыг захиалагч бүрэн хариуцна.
- 6.2 Бүтээгдэхүүнийг хүлээн авахдаа тоолж, шалгаагүйн улмаас үүсэх төлбөр, дутсан бараа, доголдолтой бүтээгдэхүүнийг захиалагч хариуцна.
- 6.3 Бүтээгдэхүүний тээвэрлэлтийн асуудлыг захиалагч хариуцах ба тээвэрлэлтийн явцад гэмтээсэн бүтээгдэхүүнийг гүйцэтгэгч хариуцахгүй.
- 6.4 Талуудын аль нэг нь гэрээнд заасан бусад үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс үүдэн учирсан хохирлыг гэрээ зөрчигч тал бүрэн хариуцна.

## 7. БУСАД ЗҮЙЛ

- 7.1. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 7.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл тухай бүр талууд харилцан тохиролцож гэрээний нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж хүчин төгөлдөр болгоно.
- 7.3. Хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд гэрээ болон хавсралтад зөрүүтэй мэдээлэл орсон тохиолдолд хавсралтын заалтыг хүчинтэйд тооцно.
- 7.4. Тус гэрээний 2.5 заасан хугацаанд хийгдэх нэмэлт ажил бүр нэмэлт дугаар бүхий хавсралт үйлдэж гэрээнд хавсаргана.
- 7.5. Энэхүү гэрээний харилцаатай холбогдон үүссэн аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд ийнхүү шийдэлд хүрч чадаагүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:


**ГҮЙЦЭТГЭГЧ:** “АДМОН ПРИНТ” ХХК,

түүнийг төлөөлж Захиалгын менежер

 У.Баттуяа

**Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Амарын гудамж-2, Адмон Принт ХХК-н байр

**Утас:** 11-329253, 91924450

**ЗАХИАЛАГЧ:** Эрүүл Мэндийн Хөгжил Төвийн Судалгаа төлөвлөлт статистик мэдээллийн албаны дарга  Ч.Зулцэцэг

**Утас:** 99069916, 77111485



\_\_\_\_\_ **ТООТ ХЭВЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**  
**ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ №-1**

2016.09.05

Улаанбаатар хот

Үндсэн захиалга:

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Хэмжээ	Тоо ширхэг	Нэгж үнэ / ₮/	Нийт үнэ / ₮/
1.	Ойн ном	В5 170 нүүр дотор-105 гр шох, хавтас- 157 гр шох, Матт бүрэлттэй.	250	9790	2 447 500
2	Эх бэлтгэл				1 360 000
	Нийт үнэ				3 807 500

Төлбөр төлөх график:

№	Огноо	Төлбөр /төгрөг/	Тайлбар
1			
2			

**ХАВСРАЛТ БАТАЛСАН:**

**ГҮЙЦЭТГЭГЧ:** “АДМОН ПРИНТ” ХХК,

түүнийг төлөөлж Захиалгын менежер

\_\_\_\_\_ У.Баттуяа

**Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р  
хороо, Амарын гудамж-2, Адмон Принт ХХК-н  
байр

**Утас:** 11-329253, 91924450

**ЗАХИАЛАГЧ: ЗАХИАЛАГЧ:** Эрүүл Мэндийн  
Хөгжил Төвийн Судалгаа төлөвлөлт статистик  
мэдээллийн албаны дарга

\_\_\_\_\_ Ч.Зулцэцэг

**Утас:** 99069916, 77111485